ЯРИЛЦЛАГА, НИЙТЛЭЛ · 2026 оны 10-р сарын 30

"ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ПРОКУРОРЫН ҮҮРГИЙН ӨӨРЧЛӨЛТ: ЯЛЛАХ АЖИЛЛАГААНААС ЭРСДЭЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАНДЛАГА РУУ"



Олон Улсын Прокурорын холбооны 2026 оны 3 улирлын товхимолд нийтлэгдсэн УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн сургалтын албаны дарга, доктор Б.Өнөрмаагийн "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд прокурорын үүргийн өөрчлөлт: Яллах ажиллагаанаас эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх хандлага руу" сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийг хүргэж байна.

Нэг. Гэр бүлийн хүчирхийлэл: эрүүгийн эрх зүйн асуудлаас нийгмийн аюулгүй байдлын сорилт руу

Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн ноцтой зөрчил төдийгүй нийгмийн хамгаалал, эрүүгийн шударга ёсны тогтолцоонд томоохон сорилт болж буй дэлхий нийтийн тулгамдсан асуудал юм. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын мэдээлснээр дэлхий даяар гурван эмэгтэй тутмын нэг нь амьдралынхаа аль нэг үед дотно харилцаатай хамтрагчийн эсхүл бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдаг бөгөөд хүчирхийллийн улмаас амь насаа алдсан эмэгтэйчүүдийн дийлэнх нь гэр бүлийн

орчинд хохирсон байдаг (WHO, 2024; UN Women & UNODC, 2024).

Гэр бүлийн хүчирхийллийн хор уршиг нь зөвхөн тухайн хохирогчоор хязгаарлагдахгүй бөгөөд хүүхдийн хөгжил, сэтгэцийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн тогтвортой байдалд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлдэг.

Монгол Улсад ч гэр бүлийн хүчирхийлэл нь тулгамдсан асуудал хэвээр байна. Албан статистик болон үндэсний судалгааны үр дүнгээс үзэхэд гэр бүлийн хүчирхийллийн зөрчил тогтмол бүртгэгдэж, хүчирхийлэлтэй холбоотой нас баралт бүртгэгдсээр байгаа бөгөөд хамтрагчтай байсан эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь амьдралынхаа туршид ямар нэг хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн байна (YCX, НҮБ-ын Хүн амын сан, 2023). Эдгээр үзүүлэлт нь гэр бүлийн хүчирхийлэл зөвхөн эрүүгийн эрх зүйн асуудал бус, нийгмийн аюулгүй байдлын тулгамдсан сорилт хэвээр байгааг харуулж байна. Ийм нөхцөлд прокурорын байгууллагын оролцоог зөвхөн гэмт хэрэг үйлдэгдсэний дараах яллах ажиллагаагаар хязгаарлах боломж улам бүр хумигдаж байна.

Сүүлийн жилүүдэд цахим технологийн хөгжилтэй холбоотойгоор цахим мөрдөн мөшгөх, байршил тогтоох төхөөрөмж ашиглан хянах, хувийн мэдээлэл болон дүрс бичлэгээр сүрдүүлэх зэрэг шинэ хэлбэрийн хүчирхийлэл нэмэгдэх болсон нь асуудлыг улам хүндрүүлж байна (United Nations Office on Drugs and Crime [UNODC], 2023).

Иймээс гэр бүлийн хүчирхийллийг зөвхөн нэг удаагийн эрүүгийн хэрэг бус, харин урьдчилан сэргийлэх, эрсдэлийг удирдах, хохирогчийг хамгаалах цогц арга хэмжээ шаардсан нийгмийн аюулгүй байдлын асуудал гэж үзэх хандлага олон улсад давамгайлах болжээ.

Энэ хүрээнд олон улсад “эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх” хандлага өргөн хэрэглэгдэх болсон бөгөөд уг ойлголт нь ноцтой хор уршиг үүсэхээс өмнө өндөр эрсдэлтэй хохирогч, нөхцөл байдлыг эрт илрүүлж, эрсдэлийн түвшинд тохирсон хамгаалалт, дэмжлэгийн арга хэмжээг хэрэгжүүлэхийг хэлдэг. Ийм хандлагад хүчирхийлэл үйлдэгдсэний дараах хариу арга хэмжээтэй адил хэмжээнд ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах асуудал чухал байр суурь эзэлдэг бөгөөд энэ нь прокурорын байгууллагын үүргийг зөвхөн яллах ажиллагаагаар хязгаарлах бус, эрсдэлийг эрт илрүүлэх, хамгаалалтын арга хэмжээг дэмжих чиглэлд өргөжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Хоёр. Зөвхөн яллах ажиллагаа хангалттай юу?

Уламжлалт байдлаар прокурорын байгууллагын үндсэн үүрэг нь гэмт хэрэг үйлдэгдсэний дараа эрүүгийн хариуцлага хүлээлгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэж ирсэн. Гэвч гэр бүлийн хүчирхийллийн онцлог нь энэ төрлийн хандлагын хязгаарлалтыг тодорхой харуулдаг.

Судалгаанаас үзэхэд гэр бүлийн хүчирхийллийн олон тохиолдол огт мэдээлэгддэггүй бөгөөд мэдээлэгдсэн хэргийн хүрээнд ч хохирогч айдас, эдийн засгийн хараат байдал, гэр бүлийн харилцаагаа хадгалах хүсэл зэрэг шалтгаанаар мэдүүлгээсээ татгалзах, эсхүл хамтран ажиллахаас зайлсхийх тохиолдол түгээмэл байдаг (UNODC, 2022). Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэл нь давтан үйлдэгдэх өндөр эрсдэлтэй бөгөөд

хүүхдүүд хүчирхийллийн мөчлөгийн давхар хохирогч болох эрсдэл өндөр байдаг (Council of Europe, 2021).

Гэр бүлийн хүчирхийллийн далд шинж, давтан үйлдэгдэх эрсдэл нь зөвхөн үйлдэгдсэн хэрэгт хариу өгөх замаар асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүйг харуулж байна. Хэдийгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зайлшгүй шаардлагатай боловч хохирогчийг хамгаалах, дахин хохирол учрахаас урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн нөхцөл шалтгааныг бууруулах нэмэлт арга хэмжээ шаардлагатай болж байна.

Үүний зэрэгцээ прокурорын байгууллагууд шинэ сорилтуудтай тулгарч байна. Тухайлбал, өндөр эрсдэлтэй хохирогчийг цаг алдалгүй илрүүлэх, байгууллага хоорондын мэдээлэл солилцоог хангах, хүүхдийн эрсдэлийг үнэлэх, цахим орчин дахь хүчирхийллийн нотлох баримтыг цуглуулах зэрэг асуудал нь улам бүр төвөгтэй болж байна.

Эдгээр сорилт нь прокуророос уламжлалт яллах чиг үүргээс гадна эрт илрүүлэлт, хамгаалалтын арга хэмжээ, байгууллага хоорондын хамтын ажиллагаанд илүү идэвхтэй оролцохыг шаардах болжээ.

Гурав. Урьдчилан сэргийлэх чиг баримжаатай прокурорын байгууллага: олон улсын туршлага

Гэр бүлийн хүчирхийллийн давтамж өндөр, далд үлдэх шинжтэй, давтан үйлдэгдэх эрсдэлтэй онцлог нь олон улсын түвшинд прокурорын байгууллагын оролцоог зөвхөн яллах ажиллагаанаас давсан, урьдчилан сэргийлэх чиг баримжаатай болгон хөгжүүлэхэд хүргэжээ.

Их Британид хэрэгжиж буй Олон байгууллагын эрсдэлийн үнэлгээний зөвлөгөөн (MARAC) нь өндөр эрсдэлтэй гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлыг олон байгууллага хамтран үнэлж, хамгаалалтын арга хэмжээг төлөвлөх тогтолцоо юм. Энэхүү тогтолцоонд прокурорын байгууллагын төлөөлөл нь эрсдэлийн мэдээллийг ашиглах, хамгаалалтын арга хэмжээг уялдуулах, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаанд оролцдог.

Европын Холбооны Хүйсийн тэгш байдлын хүрээлэнгийн (EIGE) эрсдэлийн үнэлгээний аргачлал нь MARAC зэрэг олон байгууллагын хамтын ажиллагаанд ашиглагддаг үнэлгээний суурь хэрэгсэл бөгөөд өндөр эрсдэлтэй хохирогчийг эрт илрүүлэх, хохирогч болон хүүхдийн аюулгүй байдлыг үнэлэх, давтан хүчирхийллийн эрсдэлийг тодорхойлоход чиглэдэг.

Эдгээр тогтолцоонд прокурор, цагдаа, эрүүл мэнд, хүүхэд хамгааллын байгууллагууд хамтран оролцож, эрсдэлийн түвшинд тохирсон хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд прокурор нь өндөр эрсдэлтэй хохирогчийг тодорхойлох, хамгаалалтын арга хэмжээг төлөвлөх, байгууллага хоорондын хамтын ажиллагааг уялдуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг (Home Office, 2024; SafeLives, 2024; EIGE, 2021).

Канад, Австрали зэрэг улс орнууд хохирогч төвтэй үйлчилгээ, эрт үеийн интервенцийн арга хэмжээг хөгжүүлснээр өндөр эрсдэлтэй гэр бүлүүдтэй хүчирхийлэл даамжрахаас өмнө ажиллах тогтолцоог бүрдүүлж байна (Department of Justice Canada, 2023;

Australian Institute of Family Studies, 2023).

Ийнхүү олон улсын туршлагаас харахад прокурорын үүрэг нь зөвхөн эрүүгийн хариуцлага хүлээлгэх ажиллагаагаар хязгаарлагдахгүй болж, эрсдэлийг үнэлэх, хохирогчийг хамгаалах, байгууллага хоорондын хамтын ажиллагааг уялдуулах чиглэлд өргөжиж байна. Үүний үр дүнд өндөр эрсдэлтэй хохирогчийг эрт илрүүлэх, эрсдэлийн үнэлгээний мэдээллийг ашиглах нь прокурорын өдөр тутмын ажлын чухал хэсэг болжээ.

Дөрөв. Монгол Улсад хэрэгжүүлэх боломж ба дүгнэлт

Олон улсын туршлагаас харахад гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үр дүнтэй тэмцэхэд прокурорын байгууллагын үүргийг зөвхөн эрүүгийн хариуцлага хүлээлгэх ажиллагаагаар хязгаарлах бус, эрсдэлийг эрт илрүүлэх, хохирогчийг хамгаалах, давтан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлд хөгжүүлэх шаардлагатай байна. Ийм өөрчлөлт нь прокурорыг зөвхөн хэрэг шийдвэрлэгч бус, харин эрсдэлийг удирдах, хохирогчийг хамгаалах, байгууллага хоорондын хамтын ажиллагааг уялдуулах чиг үүрэгтэй оролцогч болгон хөгжүүлэхийг шаардаж байна.

Хэдийгээр Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт бүрдсэн боловч эрсдэлийн үнэлгээний аргачлалыг тогтмол ашиглах, байгууллага хооронд мэдээлэл солилцох, давтан хүчирхийллийг урьдчилан тодорхойлох чиглэлд тодорхой хүндрэл бэрхшээл байсаар байна. Энэ нь урьдчилан сэргийлэх болон хамгаалалтын арга хэмжээний үр нөлөөг бууруулах эрсдэлтэй юм.

Монгол Улсын хувьд эрсдэлийн үнэлгээний аргачлалыг үе шаттай нэвтрүүлэх, байгууллага хоорондын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх, нотолгоонд суурилсан эрсдэлийн зураглал боловсруулах шаардлага хэвээр байна. Мөн цахим орчин дахь хүчирхийллийн шинэ хэлбэрүүд нэмэгдэж буй нөхцөлд прокурорын цахим нотлох баримттай ажиллах ур чадвар, олон байгууллагын хамтын ажиллагаа, хохирогч төвтэй хандлагыг бэхжүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцлийн зорилго нь зөвхөн гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх бус, харин дараагийн хохирогч бий болохоос өмнө эрсдэлийг илрүүлж, хамгаалалтыг хангахад оршино.

Иймээс орчин үеийн прокурорын байгууллагын үр нөлөөг зөвхөн ял шийтгүүлсэн этгээдийн тоогоор бус, өндөр эрсдэлтэй нөхцөл байдлыг цаг тухайд нь илрүүлсэн, хохирогчийн аюулгүй байдлыг хангаж чадсан, давтан хүчирхийллээс урьдчилан сэргийлсэн бодит үр дүнгээр үнэлэх нь зүйтэй. Энэ утгаараа гэр бүлийн хүчирхийллийн хүрээнд амжилттай прокурорын ажиллагаа гэдэг нь зөвхөн үйлдэгдсэн гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх бус, ирээдүйд учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлж чадсан байхыг мөн илэрхийлнэ.

Эх сурвалж: **Олон Улсын Прокурорын холбооны товхимол 2026 он №101**